



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 436

Улаанбаатар хот

Хорооны 2019 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан
журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагааны багц дүрэм”-ийн нэгдүгээр хавсралт “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 8 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай заалтыг нэмсүгэй:

1/ 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт 8.1. 10¹ дахь заалт:


“8.1.10¹. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль зөрчсөн”.

2. Мөн журмын 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3.1.8 дахь заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулсугай:

1/ “3.1.8. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын хөтөлбөр”.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН